



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 06

Эрдэнэт


Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл  
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “б” дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн 2020 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 72,861,914.7 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 57,749,827.0 мянган төгрөгөөр, төсвийн хэмнэлтийг 8,944,766.0 мянган төгрөгөөр, зарлагаас давсан орлогыг 6,167,321.0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

2. Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ